



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2024 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.05 № 274

танай _____ ны № _____ Т

“ИНГЭТ ДӨЛ” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.БАЯРЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Ингэт дөл” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

“Ингэт дөл” ОНӨААТҮГ нь 2023 онд сэлбэг хэрэгслийн зардалд 11.7, шатахууны зардалд 47.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан боловч бараа материалын тайланд орлого, зарлагаар тусгаж тайлагнаагүй, нярвын тайлан гаргаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион

000020687

байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;”, байгууллагын дүрмийн 9 дүгээр зүйлийн 4-т “үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг үйлдвэрийн газрын дарга, нягтлан бодогч хариуцна” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийт 58.9 сая төгрөгийн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс илүү илэрхийлэгдэж санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь 2023 онд 0.7 сая төгрөгийн эхний үлдэгдэл дээр нийт 89.0 сая төгрөгийн орлого олж гүйцэтгэлээр 89.4 сая төгрөгийг зарцуулж 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Аудитын гол асуудал

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 9.7 сая төгрөгийн өглөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан нь өмнөх оноос 4.1 сая төгрөг буюу 10.8 хувиар өглөг нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

ОНХС-гийн 62.0, сумын ЗДТГ-аас 15.0, ЗДНХ-өөс 5.0 сая төгрөгийн хөрөнгөөр гүүр, зам засварын 6 ажлыг, БХС-гийн 7.0 сая төгрөгийн хөрөнгөөр хог цэвэрлэгээний 1 ажлыг тус тус гүйцэтгэж ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,797,952.50	4,336,054.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	759,292.52	297,394.54
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	759,292.52	297,394.54
31210	Төгрөг	759,292.52	297,394.54
31213	Арилжааны банк дахь харилцах	759,292.52	297,394.54
33	АВЛАГА	1,499.98	1,499.98
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1,499.98	1,499.98
35	БАРАА МАТЕРИАЛ	4,037,160.00	4,037,160.00
35400	Хангамжийн материал	4,037,160.00	4,037,160.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,037,160.00	4,037,160.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	211,970,000.61	140,170,500.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	211,970,000.61	140,170,500.54
39200	Биет хөрөнгө	211,970,000.61	140,170,500.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	244,750,000.76	244,750,000.76
39204	Хуримтлагдсан элэгдэл	-84,150,000.15	-117,425,000.22
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	102,740,000.00	102,740,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,370,000.00	-89,894,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	216,767,953.11	144,506,555.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,651,456.92	9,747,618.82
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,651,456.92	9,747,618.82
41300	Өглөг	5,651,456.92	9,747,618.82
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,522,135.00	3,872,135.00

41360	Бусад өглөг	4,129,321.92	5,875,483.82
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	4,129,321.92	5,862,983.82
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.00	12,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	211,116,496.19	134,758,936.24
51	Засгийн газрын хувь оролцоо	211,116,496.19	134,758,936.24
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	347,490,000.76	347,490,000.76
51200	Хуримтлагдсан үр дүн	-136,373,504.57	-212,731,064.52
51210	Өмнөх үеийн үр дүн	-93,932,558.71	-136,373,504.57
51220	Тайлант үеийн үр дүн	-42,440,945.86	-76,357,559.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	216,767,953.11	144,506,555.06

Санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,479,817.27	89,000,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,479,817.27	89,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,479,817.27	89,000,000.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	112,144,100.00	89,000,000.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	84,664,282.73	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	69,920,763.13	165,357,559.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,920,763.13	165,357,559.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,920,763.13	165,357,559.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,371,763.05	93,558,059.88
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	26,371,763.05	93,558,059.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,549,000.08	71,799,500.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,549,000.08	71,799,500.07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-42,440,945.86	-76,357,559.95
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-42,440,945.86	-76,357,559.95

VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

Мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	112,073,600.0 0	89,000,000.0 0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,073,600.0 0	89,000,000.0 0
120	Нийтлэг татварын бус орлого	112,073,600.0 0	89,000,000.0 0
12001 3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	112,073,600.0 0	89,000,000.0 0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,328,869.8 7	89,461,897.9 8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,328,869.8 7	89,461,897.9 8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	111,328,869.8 7	89,461,897.9 8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,589,864.00	9,600,000.00
21010 6	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	17,589,864.00	9,600,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,819,200.00	2,288,300.00
21020 6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	4,819,200.00	2,288,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,656,163.14	0.00
21030 5	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	2,656,163.14	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,263,642.73	77,573,597.9 8
21081 6	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,599,360.00	6,751,215.81

21081 8	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	84,664,282.73	70,822,382.1 7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	744,730.13	-461,897.98
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	744,730.13	-461,897.98
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,562.39	759,292.52
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	759,292.52	297,394.54

Өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	347,490,000.76	0.00	-93,932,558.71	253,557,442.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	347,490,000.76	0.00	-93,932,558.71	253,557,442.05
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-42,440,945.86	-42,440,945.86
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	347,490,000.76	0.00	-136,373,504.57	211,116,496.19
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	347,490,000.76	0.00	-136,373,504.57	211,116,496.19
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	347,490,000.76	0.00	-136,373,504.57	211,116,496.19

14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-76,357,559.95	-76,357,559.95
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	347,490,000.76	0.00	-212,731,064.52	134,758,936.24

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 59.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 58.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Залруулсан алдаа:

Залруулсан алдаа илрээгүй болно.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 59.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 57.9 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалтай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Төсөвт тусгагдаагүй, цалингийн зардлаас үндэслэлгүйгээр 0.5 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, Орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.3-т “үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах;” НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ.”, 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэсэн заалтуудыг зөрчсөн тул төлбөрийн акт бичлээ.

5.2 Албан шаардлага

5.2.1 Сэлбэг хэрэгслийн зардалд 11.7, шатахууны зардалд 47.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан боловч бараа материалын тодруулга тайланд орлого, зарлагаар тайлагнаагүй, нярвын тайлан гаргаж ажиллаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;”, байгууллагын дүрмийн 9 дүгээр зүйлийн 4-т “үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг үйлдвэрийн газрын дарга, нягтлан бодогч хариуцна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

Холбогдох зөвлөмжийг сумын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар ТШЗ-д хүргүүлж ажиллахаар болсон.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тушаал, шийдвэр, үндэслэлгүйг ээр зардал зарцуулсан.	1	0.5	1	0.5								
Сэлбэг, шатахууны орлого, зарлагыг тайлагнаагүй, нярвын тайлан хийгээгүй.	1	58.8			1	58.8						
Дүн	2	59.3	1	0.5	1	58.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

	Нийт зөрчил	Үүнээс
--	-------------	--------

Аудитад хамрагдсан байгууллагын нэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААТҮГ	1					1		
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1					1		

